ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙГ ШИЛЖҮҮЛЭХ, СЭЛГЭН АЖИЛЛУУЛАХ СУЛ ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ, ТУСГАЙ ШАЛГАЛТ, ЭЛСЭЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗАР

1.Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын дагуу төрийн өөр байгууллага, нэгж хооронд шилжин ажиллахыг хүссэн төрийн жинхэнэ албан хаагч болон иргэдийг тусгай шалгалтад бүртгүүлэхийг урьж байна.

Тавигдах болзол, шаардлага:
-Төрийн жинхэнэ албан тушаалд зохих ёсоор томилогдсон байх;
-Зарлагдсан албан тушаалтай адил төрөл болон адил ангилалд ажилладаг байх;
-Зарлагдсан албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг хангасан байх.

Бүрдүүлэх материал:
-Төрийн албанд ажиллаж буй албан хаагчийн тодорхойлолт (И-Монголоос) (.pdf);
-Төрийн албан хаагчийн анкет (Төрийн албаны зөвлөлийн 2025.11.19-ний 521 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам” нэгдүгээр хавсралт маягт, хоёрдугаар хавсалт зааврын дагуу үнэн зөв бичсэнээ баталгаажуулсан байх, шивсэн байхыг зөвшөөрнө) (.pdf);
-Иргэний үнэмлэхийн лавлагаа (И-Монголоос) (.pdf);
-Боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичиг (диплом), хэрэв гадаад улсад их, дээд сургууль төгссөн бол боловсролын баримт бичгийн баталгаат орчуулгыг хавсаргах;
-Мэргэшүүлэх сургалтад хамрагдсаныг гэрчлэх баримт бичиг;
-Нийгмийн даатгалын дэвтэр (хөдөлмөрийн дэвтэр)-ийн хуулбар, цахим лавлагаа;
-Ажиллаж байсан байгууллагуудын архивын лавлагаа;
-Албан тушаалд томилогдсон, чөлөөлөгдсөн тушаал, шийдвэрийн хуулбар, архивын лавлагаа;
-Ажил байдлын тодорхойлолт (байгууллагын удирдлагаар албажуулсан хувь болон файлыг вөрд хувилбараар);
-Хүний нөөцийн мэдээллийн сан (программ)-ийн дэлгэрэнгүй анкет, танилцуулга;
-Томилолтын карт;
-Тангаргийн хуудас;
-Сүүлийн гурван жилийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээний хуудас;
-Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт (И-Монголоос) (.pdf);
-Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тухай тодорхойлолт (И-Монголоос) (.pdf).

2.Дотоод хэргийн их сургуулийн ахлагч албан тушаалын сул орон тоог нөхөх, нөөц бүрдүүлэх зорилгоор тус Их сургуулийн “Ахлагч” мэргэжлийн боловсролын сургуулийн мэргэжил олгох сургалтад хугацаат цэргийн алба хаасан, бүрэн дунд болон түүнээс дээш боловсролтой иргэдийг бүртгүүлэхийг урьж байна.

Тавигдах ерөнхий шаардлага:

-Монгол Улсын иргэн байх;

-Монгол хэлний ярианы болон бичгийн чадвартай байх (Монгол хэл бичгийн дүрэм, үг зүй, найруулга зүйн зохих мэдлэгтэй);

-Гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлж байгаагүй;

-Сэтгэцийн өвчин, эмгэггүй байх;

-Бүрэн дунд болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх;

-Хуулийн дагуу цэргийн жинхэнэ алба хаах үүрэг хүлээсэн иргэн үүргээ биелүүлсэн байх (цэргийн албыг биеэр хаасан болон оюутан цэрэг, дүйцүүлэн хаасан).

Тавигдах тусгай шаардлага:

-30 хүртэл настай;

-Сахилга, ёс зүйг сахиж, тогтвор суурьшилтай, хариуцлагатай ажиллах;

-Нөхцөл байдлыг зөв үнэлж, шийдвэр гаргах, багаар ажиллах, зөв боловсон харилцах ур чадвар эзэмшсэн байх, хувийн зохион байгуулалт сайтай, ажлын ачаалал даах чадвартай байх;

-Албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг хангасан байна.

Албан тушаал (ажлын байр)-д дээр дурдсан ерөнхий болон тусгай шаардлагыг хангаж байгаа иргэд бүртгэл, судалгаанд хамрагдана.

Бүрдүүлэх материал:

-Өргөдөл (.pdf);

-Төрийн албан хаагчийн анкет (Төрийн албаны зөвлөлийн 2025.11.19-ний 521 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам” нэгдүгээр хавсралт маягт, хоёрдугаар хавсалт зааврын дагуу үнэн зөв бичсэнээ баталгаажуулсан байх, шивсэн байхыг зөвшөөрнө) (.pdf);

-Төрсний бүртгэлийн лавлагаа (И-Монголоос) (.pdf);

-Иргэний үнэмлэхийн лавлагаа (И-Монголоос) (.pdf);

-3 үеийн 7 хүний намтар (өөрийн, эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх) (.pdf);

-Хорооны засаг даргын тодорхойлолт (И-Монголоос) (.pdf);
-Иргэний оршин суугаа газрын хаягийн бүртгэлийн лавлагаа (И-Монголоос) (.pdf);
-Сурагчийн хувийн хэрэг (.pdf);
-Боловсролын түвшнийг тодорхойлсон баримт бичиг (диплом), хэрэв гадаад улсад их, дээд сургууль төгссөн бол боловсролын баримт бичгийн баталгаат орчуулгыг хавсаргах; (.pdf);
-Цэргийн үүрэгтний үнэмлэх (.pdf);
-Урьд нь ажил, хөдөлмөр эрхэлж байсныг гэрчлэх баримт (нийгмийн даатгалын дэвтэр, хөдөлмөрийн дэвтэр)-ийн эх хувь; албанаас чөлөөлөгдсөн бол тушаалын хувь, архивын лавлагаа (.pdf);
-Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт (И-Монголоос) (.pdf);
-Ажиллаж байсан байгууллагуудын архивын лавлагаа;
-Гадаад хэлний мэдлэгийн түвшин тогтоолгосон хуудас;
-Төрийн албаны ерөнхий шалгалт өгч нөөцөд бүртгэгдсэн баримт;
-Тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн лавлагаа, тодорхойлолт
-Шагналын үнэмлэхийн хуулбар (.pdf);
-Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт (И-Монголоос) (.pdf);
-Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тухай тодорхойлолт (И-Монголоос) (.pdf);
-“3*4, 4*6” хэмжээтэй цээж зураг тус бүр 2 хувь; (.jpeg);
-Эрүүл мэндийн хуудас (Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг) (.pdf);
-Сэтгэцийн эмчийн үзлэг, дүгнэлт (Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв) (.pdf).

Хүлээн авах:
-Хугацаа: 2026 оны 04 дугаар сарын 17-ны өдрийн 17.00 цаг хүртэл
-Хүлээн авах хаяг: hruia@uia.gov.mn цахим шуудан
-Холбоо барих утас: 89119156, 92906699

Жич: Цаасан суурьтай өргөдөл, хавсралт баримт бичгийн бүрдлийг бүрэн хангаж, Дотоод хэргийн их сургуулийн төв байрны 120 тоотод хүлээлгэн өгнө.

Шилжүүлэх, сэлгэн ажиллуулах, тусгай шалгалт болон элсэлт зохион байгуулах албан тушаалын сул орон тооны жагсаалт

№	Дотоод нэгж	Албан тушаал	Орон тоо	Албан тушаалын		Албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлага			
				Төрөл	ангилал, зэрэглэл	Боловсрол	Мэргэжил	Мэргэшил	Туршлага
Нэг.Офицер бүрэлдэхүүн									
1	Эрдэм шинжилгээ, инновацын газар	Эрдмийн болон хамгаалуулах зөвлөл хариуцсан чиглэлийн ахлах мэргэжилтэн	1	Төрийн тусгай	ТТ-4	Магистр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй	042101 Эрх зүйч, тухайн албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэргэжилтэй байх.	Мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, төгссөн байх, Шаардлагатай бол тухайн албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэргэжлийн чиглэлээр мэргэшсэн байх.	Төрийн албанд 10-аас доошгүй жил, үүнээс ахлах багш болон түүнтэй адилтгах ахлах мэргэжилтний албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх.
2	Эрдэм шинжилгээ, инновацын газрын Багш, суралцагчийн хөгжлийн төв	Чиглэлийн ахлах мэргэжилтэн	1	Төрийн тусгай	ТТ-4	Магистр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй	0114 багш, 042101 эрх зүйч, тухайн албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэргэжилтэй	Мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, төгссөн байх, Шаардлагатай бол тухайн албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэргэжлийн чиглэлээр мэргэшсэн байх.	Төрийн албанд 10-аас доошгүй жил, үүнээс ахлах багш болон түүнтэй адилтгах ахлах мэргэжилтний албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх.
3	Эрдэм шинжилгээ, инновацын газрын Мэдээллийн технологийн төв	Цахим шилжилт, дэвшилтэт технологи хариуцсан чиглэлийн ахлах мэргэжилтэн	1	Төрийн тусгай	ТТ-4	Магистр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй	061201 Компьютерын сүлжээ, 061202 Кибер аюулгүй байдал, 061303 Мэдээллийн систем, 061304 Мэдээллийн технологи, 042101	Мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, төгссөн байх, Шаардлагатай бол тухайн албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэргэжлийн	Төрийн албанд 10-аас доошгүй жил, үүнээс ахлах багш болон түүнтэй адилтгах ахлах мэргэжилтний албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх.

							Эрх зүй	чиглэлээр мэргэшсэн байх.	
4	Эрдэм шинжилгээ, инновацын Хэвлэл, редакцын төв	Ахлах редактор	1	Төрийн тусгай	ТТ-4	Магистр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй	042101 Эрх зүйч, 032101 сэтгүүл зүй, тухайн албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэргэжилтэй байх.	Мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, төгссөн байх, Шаардлагатай бол тухайн албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэргэжлийн чиглэлээр мэргэшсэн байх.	Төрийн албанд 6-аас доошгүй жил, үүнээс мэргэжилтэн, түүнтэй адилтгах албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан байх
5	Сургалтын газрын Е-сургалтын институт	Системийн шинжээч	1	Төрийн тусгай	ТТ-4	Магистр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй	061304 Мэдээллийн технологи, 061301 Компьютерын ухаан, 061302 Программ хангамж, 061303 Мэдээллийн систем, 042101 Эрх зүйч	Мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, төгссөн байх, Шаардлагатай бол тухайн албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэргэжлийн чиглэлээр мэргэшсэн байх.	Төрийн албанд 10-аас доошгүй жил, үүнээс ахлах багш болон түүнтэй адилтгах ахлах мэргэжилтний албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх.
6	Сургалтын газрын Гадаад хэлний институт	Сургалтын арга зүйч	1	Төрийн тусгай	ТТ-4	Магистр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй	0114 багш, 042101 эрх зүйч, 011101 Боловсрол, тухайн албан тушаалын чиглэлд хамаарах мэргэжилтэй байх.	Боловсрол судлал чиглэлээр мэргэшсэн сургалтад хамрагдаж батламж авсан эсвэл төгссөн байх.	Төрийн албанд 10-аас доошгүй жил, үүнээс ахлах багш болон түүнтэй адилтгах ахлах мэргэжилтний албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх.

7	Сургалтын газрын Гадаад хэлний институт (англи хэл)	Багш	2	Төрийн тусгай	ТТ-6	Магистр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй	0114 багш, 042101 эрх зүйч, тухайн албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэргэжилтэй	Багшлах эрхтэй, гадаад хэлний олон улсын жишиг шалгалтын оноо (TOIEC 800-850; HSK5-6; ТРКИ-С1-С2)-той байх Тухайн албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэргэжлийн чиглэлээр мэргэшсэн байх	Төрийн албанд 3-аас доошгүй жил ажилласан байх
8	Удирдлагын академийн Цагдаа, дотоодын цэргийн удирдлага, стратегийн тэнхим	Ахлах багш	1	Төрийн тусгай	ТТ-5	Магистр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй	0114 багш, 042101 эрх зүйч, тухайн чиг үүрэгт хамаарах мэргэжилтэй	Багшлах эрхтэй байх, тухайн албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэргэжлийн чиглэлээр мэргэшсэн байх	Төрийн албанд 6-аас доошгүй жил, үүнээс багш болон түүнтэй адилтгах албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан байх
9	Удирдлагын академийн Онцгой байдлын удирдлага, стратегийн тэнхим	Дэд профессор	1	Төрийн тусгай	ТТ-4	Доктор болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй	0114 багш, 042101 эрх зүйч, тухайн чиг үүрэгт хамаарах мэргэжилтэй	Багшлах эрхтэй байх, тухайн албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэргэжлийн чиглэлээр мэргэшсэн байх	Төрийн албанд 10-аас доошгүй жил, үүнээс ахлах багш болон түүнтэй адилтгах албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх
10	Удирдлагын академийн Онцгой байдлын удирдлага, стратегийн тэнхим	Ахлах багш	1	Төрийн тусгай	ТТ-5	Магистр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй	0114 багш, 042101 эрх зүйч, тухайн чиг үүрэгт хамаарах мэргэжилтэй	Багшлах эрхтэй байх, тухайн албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэргэжлийн чиглэлээр мэргэшсэн байх	Төрийн албанд 6-аас доошгүй жил, үүнээс багш болон түүнтэй адилтгах албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан байх
11	Цагдаагийн сургуулийн	Багш	1	Төрийн тусгай	ТТ-6	Магистр болон түүнээс дээш	0114 багш, 042101 эрх зүйч, тухайн	Багшлах эрхтэй байх, тухайн	Төрийн албанд 3-аас доошгүй жил

	Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхим					боловсролын зэрэгтэй	чиг үүрэгт хамаарах мэргэжилтэй	албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэргэжлийн чиглэлээр мэргэшсэн байх	ажилласан байх
12	Цагдаагийн сургуулийн Мөрдөх арга зүйн тэнхим	Ахлах багш	1	Төрийн тусгай	ТТ-5	Магистр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй	0114 багш, 042101 эрх зүйч, тухайн чиг үүрэгт хамаарах мэргэжилтэй	Багшлах эрхтэй байх, тухайн албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэргэжлийн чиглэлээр мэргэшсэн байх	Төрийн албанд 6-аас доошгүй жил, үүнээс багш болон түүнтэй адилтгах албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан байх
13	Цагдаагийн сургуулийн Дотоодын цэргийн албаны тэнхим	Багш	1	Төрийн тусгай	ТТ-6	Магистр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй	0114 багш, 042101 эрх зүйч, тухайн чиг үүрэгт хамаарах мэргэжилтэй	Багшлах эрхтэй байх, тухайн албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэргэжлийн чиглэлээр мэргэшсэн байх	Төрийн албанд 3-аас доошгүй жил ажилласан байх
14	Хилийн албаны сургууль	Дамжааны захирагч-багш	1	Төрийн тусгай	ТТ-7	Бакалавр ба түүнээс дээш зэрэгтэй	042101 эрх зүйч, тухайн чиг үүрэгт хамаарах мэргэжилтэй	Мэргэшүүлэх багц сургалтад хамрагдсан байх.	Төрийн албанд 3-аас доошгүй жил ажилласан байх
15	Хилийн албаны сургуулийн Хилийн албаны тэнхим	Дэд профессор	1	Төрийн тусгай	ТТ-4	Доктор болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй	0114 багш, 042101 эрх зүйч, тухайн чиг үүрэгт хамаарах мэргэжилтэй	Багшлах эрхтэй байх, тухайн албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэргэжлийн чиглэлээр мэргэшсэн байх	Төрийн албанд 10-аас доошгүй жил, үүнээс ахлах багш болон түүнтэй адилтгах албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх
16	Хилийн албаны сургуулийн Хилийн боомтын аюулгүй байдал, шалган	Дэд профессор	1	Төрийн тусгай	ТТ-4	Доктор болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй	0114 багш, 042101 эрх зүйч, тухайн чиг үүрэгт хамаарах мэргэжилтэй	Багшлах эрхтэй байх, тухайн албан тушаалын чиг үүрэгт хамаарах	Төрийн албанд 10-аас доошгүй жил, үүнээс ахлах багш болон түүнтэй адилтгах албан

	нэвтрүүлэх албаны тэнхим							мэргэжлийн чиглэлээр мэргэшсэн байх	тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх
17	Хууль зүйн сургууль	Сургалтын арга зүйч	1	Төрийн тусгай	ТТ-4	Магистр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй	0114 багш, 042101 эрх зүйч, 011101 Боловсрол, тухайн албан тушаалын чиглэлд хамаарах мэргэжилтэй байх.	Боловсрол судлал чиглэлээр мэргэшсэн сургалтад хамрагдаж батламж авсан эсвэл төгссөн байх.	Төрийн албанд 10-аас доошгүй жил, үүнээс ахлах багш болон түүнтэй адилтгах ахлах мэргэжилтний албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх.
18	Хууль зүйн сургуулийн Хувийн эрх зүйн тэнхим	Ахлах багш	1	Төрийн тусгай	ТТ-5	Магистр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй	0114 багш, 042101 эрх зүйч, тухайн чиг үүрэгт хамаарах мэргэжилтэй	Багшлах эрхтэй байх, тухайн албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэргэжлийн чиглэлээр мэргэшсэн байх	Төрийн албанд 6-аас доошгүй жил, үүнээс багш болон түүнтэй адилтгах албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан байх
19	Хууль зүйн сургуулийн Хувийн эрх зүйн тэнхим	Багш (нөөц бүрдүүлэх)	1	Төрийн тусгай	ТТ-6	Магистр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй	0114 багш, 042101 эрх зүйч, тухайн чиг үүрэгт хамаарах мэргэжилтэй	Багшлах эрхтэй байх, тухайн албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэргэжлийн чиглэлээр мэргэшсэн байх	Төрийн албанд 3-аас доошгүй жил ажилласан байх
20	Хууль зүйн сургуулийн Нийгмийн ухааны тэнхим	Дэд профессор	1	Төрийн тусгай	ТТ-4	Доктор болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй	0114 багш, 042101 эрх зүйч, тухайн чиг үүрэгт хамаарах мэргэжилтэй	Багшлах эрхтэй байх, тухайн албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэргэжлийн чиглэлээр мэргэшсэн байх	Төрийн албанд 10-аас доошгүй жил, үүнээс ахлах багш болон түүнтэй адилтгах албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх
21	Ахлагч” мэргэжлийн боловсролын сургуулийн	Сэтгэл зүйч, нийгмийн ажилтан-багш	1	Төрийн тусгай	ТТ-6	Бакалавр ба түүнээс дээш зэрэгтэй	0313 сэтгэл судлал, тухайн албан тушаалын чиг үүрэгт	Мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, төгссөн байх.	Төрийн албанд 3-аас доошгүй жил ажилласан байх

	Цэргийн албаны зохион байгуулалтын тэнхим						хамаарах мэргэжилтэй.		
Хоёр.Ахлагч бүрэлдэхүүн									
1	Санхүү, ар талын газрын Санхүү, төлөвлөлтийн хэлтэс	Нярав	1	Төрийн тусгай	ТТ-9	Дээд боловсролтой	031101 Эдийн засаг, тухайн албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэргэжилтэй	Архив, албан хэрэг хөтлөлтийн болон ахлагч бэлтгэх сургалтад хамрагдсан байх	Шаардахгүй
2	Сургалтын газрын Албаны бэлтгэлийн “Соёмбо” төв	Заал, техник хариуцсан лаборант	1	Төрийн тусгай	ТТ-9	Дээд боловсролтой	032202 архив судлал, техникч, бусад	Архив, албан хэрэг хөтлөлтийн болон ахлагч бэлтгэх сургалтад хамрагдсан байх	Шаардахгүй
3	Бүрэлдэхүүн болон харьяа сургууль, институт	Лаборант	1	Төрийн тусгай	ТТ-9	Дээд боловсролтой	042101 эрх зүйч, 032202 архив судлал, тухайн албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэргэжилтэй	Ахлагч бэлтгэх сургалтад хамрагдаж төгссөн байх	Шаардахгүй
4	Санхүү, ар талын газрын Ар тал, хангалтын хэлтэс	Цахилгаанчин	1	Төрийн тусгай	ТТ-9	Бүрэн дунд болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй	0713 Цахилгаанчин	Цахилгаан хангамж, угсралт, гагнуур, Ахлагч бэлтгэх сургалтад хамрагдаж төгссөн байх	Мэргэжлээрээ 2-оос доошгүй жил ажилласан байх
5	Цэргийн зохион байгуулалт, аюулгүй байдлын газрын Эрүүл мэндийн төв	Сувилагч	1	Төрийн тусгай	ТТ-9	Дээд боловсролтой	091301 сувилахуй. Ахлагч бэлтгэх сургалтад хамрагдаж төгссөн байх.	Ахлагч бэлтгэх сургалтад хамрагдаж төгссөн байх	Шаардахгүй

3.Дотоод хэргийн их сургуулийн төрийн үйлчилгээний албан тушаалын дараах сул орон тоонд ажиллахыг урьж байна:

1.Нярав (ТҮ-4)

2.Сантехникийн засварчин (ТҮ-3)

3.Цахилгаанчин (ТҮ-3)

Жич: Төрийн үйлчилгээний албан тушаалд хөгжлийн бэрхшээлтэй иргэн бүртгүүлж болно.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ДЭРГЭДЭХ САЛБАР ЗӨВЛӨЛ